



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД
Ц.САНДАГ-ОЧИР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.06.18 № 38

Байгаль орчны үнэлгээ хийх тусгай
зөвшөөрөл олголтын талаар

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд олон нийтийн болон салбарын хүрээнд шүүмжлэл дагуулж байна. Тухайлбал, байгаль орчны үнэлгээ бодит нөхцөлд нийцэхгүй байгаа асуудал, захиалагчийн ашиг сонирхлоос хэт хамааралтай ажиллаж байна гэх шүүмжлэл, тусгай зөвшөөрөл олголтын ил тод байдал, мэргэжлийн байгууллагуудын хүний нөөц, чадавх, хуурамч болон чанаргүй үнэлгээний тайлан гаргасан асуудал, хариуцлага, хяналтын тогтолцоо сул байгаа зэрэг асуудал олонтаа хөндөгдөж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

- 1.Байгаль орчны үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага;
- 2.Сүүлийн 10 жилийн байдлаарх сонгон шалгаруулалтын болон байгаль орчны үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагын тоо, ангилал, үйл ажиллагааны чиглэл, үүнээс олгосон, түдгэлзүүлсэн, цуцалсан тусгай зөвшөөрлийн тоон мэдээлэл;
- 3.Байгаль орчны үнэлгээ хийх эрх бүхий байгууллагуудын мэргэжлийн хүний нөөц, лабораторийн хүчин чадлын талаарх мэдээлэл;
- 4.Байгаль орчны үнэлгээний тайланг хуулбарласан, бодит бус мэдээлэл агуулсан, чанарын шаардлага хангаагүй, мөн ашиг сонирхлын зөрчилтэй гэж тогтоогдсон тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл;
- 5.Уул уурхай болон томоохон бүтээн байгуулалтын төслүүдэд хийсэн байгаль орчны үнэлгээний чанар, хэрэгжилтэд хийсэн аудит, хяналт шалгалтын дүнгийн талаарх мэдээлэл;
- 6.Байгаль орчны үнэлгээ хийх эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд тавих төрийн хяналт, мэргэжлийн холбоодын оролцоо, ёс зүйн хариуцлагын өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл;

2026000110

7.Байгаль орчны үнэлгээний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, мэргэжлийн байгууллагуудын хараат бус байдлыг хангах, тусгай зөвшөөрөл олголтыг ил тод болгох чиглэлээр Засгийн газраас баримталж буй бодлого, эрх зүйн шинэчлэлтийн талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.УЯНГА

2026000110